

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/109/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70005329 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН ДАРГА
Л.ДАМДИНСҮРЭН ТАНАА

2022.02.16 № 38
танай _____-ны № _____-г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын өмнөд бүс дэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын өмнөд бүс дэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

016323047

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЦЭРЭНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,557,261.71	57,739,024.51
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
31130	Нэмэлт санхүүжилт		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
321	Үнэт цаас	-	-
32110	Төгрөг		
33	АВЛАГА	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	46,557,261.71	57,739,024.51
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	46,557,261.71	57,739,024.51
35410	Бичиг хэргийн материал	1,436,650.00	915,950.00
35420	Аж ахуйн материал	3,390,229.00	4,826,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Тулш, шатах тослох материал	4,529,000.00	4,880,000.00
35470	Бусад хангамжийн материал	37,201,382.71	47,116,174.51
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	246,389,162.98	328,314,538.51
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
371	Урт хугацаат хадгаламж	-	-
372	Үнэт цаас	-	-
373	Урт хугацаат зээл	-	-
37310	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	246,389,162.98	328,314,538.51
392	Биет хөрөнгө	210,722,912.98	293,143,288.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	122,491,354.28	122,491,354.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,270,070.36)	(9,090,306.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,440,000.00	27,440,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,766,666.61)	(20,981,666.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,027,809.04	174,235,496.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(85,110,656.10)	(109,760,683.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,090,800.00	136,962,710.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,179,657.27)	(28,153,615.11)
393	Биет бус хөрөнгө	35,666,250.00	35,171,250.00
39301	Программ хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,113,750.00)	(1,608,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,800,000.00	34,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	292,946,424.69	386,053,563.02

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
4111	Төгрөг	-	-
4112	Гадаад валют	-	-
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
4121	Төгрөг	-	-
4122	Гадаад валют	-	-
413	Өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
414	Урьдчилж орсон орлого	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
421	Урт хугацаат үнэт цаас	-	-
4211	Төгрөг	-	-
4212	Гадаад валют	-	-
422	Урт хугацаат зээл	-	-
4221	Төгрөг	-	-
4222	Гадаад валют	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	299,777,550.97	386,053,563.02
51	Засгийн газрын хувь оролцоо	299,777,550.97	386,053,563.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	34,800,000.00	34,800,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	34,800,000.00	34,800,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	218,922,437.97	305,198,450.02
51210	Өмнөх үеийн үр дүн	190,122,745.75	212,091,311.69
51220	Тайлант үеийн үр дүн	28,799,692.22	93,107,138.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,055,113.00	46,055,113.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	299,777,550.97	386,053,563.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	552,013,629.39	555,191,177.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,577,429.39	159,477,577.06
120	Нийтлэг татварын бус орлого	77,577,429.39	159,477,577.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,577,429.39	159,477,577.06
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,577,429.39	159,477,577.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474,436,200.00	395,713,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	474,436,200.00	395,713,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,436,200.00	395,713,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	524,580,139.62	461,249,822.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,580,139.62	461,249,822.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,389,161.52	450,238,641.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,626,933.75	278,962,296.96
210101	Үндсэн цалин	183,204,513.36	186,162,589.90
210102	Нэмэгдэл	54,178,679.99	48,306,048.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,868,000.00	35,606,500.00

210104	Урамшуулал	18,375,740.40	8,887,158.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,700,728.49	34,918,307.28
210201	Тэтгэврийн даатгал	24,098,976.29	24,478,076.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,154,450.70	2,711,210.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,824,531.85	2,209,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	629,292.35	507,838.24
210205	Эрүүл мэндийн даатгал	5,993,477.30	5,011,382.21
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,383,749.03	18,598,199.53
210301	Гэрэл, цахилгаан	6,534,500.00	4,066,599.53
210304	Байрны түрээс	13,849,249.03	14,531,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,986,616.83	35,838,818.70
210401	Бичиг хэрэг	5,478,723.00	3,860,700.00
210402	Тээвэр, шатахуун	16,867,500.00	14,593,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,825,706.13	3,187,389.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,167,495.00	2,104,029.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	14,647,192.70	12,093,600.70
2105	Норматив зардал	1,377,900.00	3,692,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,377,900.00	3,692,180.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,187,850.00	9,395,274.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,500,000.00	4,395,274.00
210604	Урсгал засвар	4,687,850.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,025,000.00	1,560,400.00
210702	Дотоод албан томилолт	2,025,000.00	1,560,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,506,626.00	2,556,552.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,800.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	992,750.00	868,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	403,036.00	215,428.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,200.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	543,700.00	1,314,300.00
210807	Газрын төлбөр	84,140.00	103,424.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	46,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,593,757.42	64,716,612.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,025,200.00	5,831,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,158,300.00	2,040,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,410,257.42	56,845,412.53
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,190,978.10	11,011,181.23

2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	3,786,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	800,000.00	3,786,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,390,978.10	7,224,781.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,390,978.10	7,224,781.23
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	27,433,489.77	93,941,354.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,382,423.83	834,216.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,382,423.83	834,216.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,382,423.83)	(834,216.50)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,051,065.94	93,107,138.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	474,436,200.00	395,713,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474,436,200.00	395,713,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	474,436,200.00	395,713,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,436,200.00	395,713,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	465,635,060.00	390,713,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,635,060.00	390,713,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,444,081.90	379,702,418.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,626,933.75	278,962,296.96
210101	Үндсэн цалин	183,204,513.36	186,162,589.90
210102	Нэмэгдэл	54,178,679.99	48,306,048.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,868,000.00	35,606,500.00
210104	Урамшуулал	18,375,740.40	8,887,158.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,700,728.49	34,918,307.28
210201	Тэтгэврийн даатгал	24,098,976.29	24,478,076.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,154,450.70	2,711,210.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,824,531.85	2,209,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	629,292.35	507,838.24
210205	Эрүүл мэндийн даатгал	5,993,477.30	5,011,382.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,383,749.03	18,598,199.53
210301	Гэрэл, цахилгаан	6,534,500.00	4,066,599.53
210304	Байрны түрээс	13,849,249.03	14,531,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,618,506.13	24,866,489.00
210401	Бичиг хэрэг	4,746,900.00	3,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,489,500.00	14,519,100.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,825,706.13	3,187,389.00
210404	Ном, хэвлэл	-	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,556,400.00	3,400,000.00
2105	Норматив зардал	473,600.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	473,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,163,000.00	11,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	98,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,500,000.00	6,800,000.00
210604	Урсгал засвар	4,565,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,025,000.00	1,560,400.00
210702	Дотоод албан томилолт	2,025,000.00	1,560,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,927,140.50	3,042,252.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,800.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	992,750.00	868,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	403,036.00	215,428.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,200.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,010,214.50	1,800,000.00
210807	Газрын төлбөр	84,140.00	103,424.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,525,424.00	5,954,474.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,367,124.00	3,914,374.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,158,300.00	2,040,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,190,978.10	11,011,181.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	3,786,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	800,000.00	3,786,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,390,978.10	7,224,781.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,390,978.10	7,224,781.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,801,140.00	5,000,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,801,140.00	5,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,800,000.00	46,055,113.00	190,122,745.75		270,977,858.75

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-82,500.00		-82,500.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,800,000.00	46,055,113.00	190,040,245.75	0.00	270,895,358.75
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			22,051,065.94		22,051,065.94
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,800,000.00	46,055,113.00	212,091,311.69	0.00	292,946,424.69
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,800,000.00	46,055,113.00	234,142,377.63	0.00	292,946,424.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,800,000.00	46,055,113.00	212,091,311.69	0.00	292,946,424.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			93,107,138.33		93,107,138.33
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,800,000.00	46,055,113.00	305,198,450.02	0.00	386,053,563.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	395,713,600.00	388,488,818.77
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	395,713,600.00	388,488,818.77
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	391,927,200.00	379,702,418.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,349,400.00	65,821,814.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	281,916,300.00	278,962,296.96
210101	Үндсэн цалин	186,956,700.00	186,162,589.90
210102	Нэмэгдэл цалин	48,834,700.00	48,306,048.86
210103	Унаа хоолны нэмэгдэл	36,478,000.00	35,606,500.00
210104	Урамшуулал	9,646,900.00	8,887,158.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,661,500.00	34,918,307.28
210201	Тэтгэврийн даатгал	27,090,500.00	24,478,076.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,787,100.00	2,711,210.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,209,800.00	2,209,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,200.00	507,838.24
210205	Эрүүл мэндийн даатгал	5,060,900.00	5,011,382.21

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,824,800.00	18,598,199.53
210301	Гэрэл, цахилгаан	4,066,600.00	4,066,599.53
210302	Түлш, халаалт	100,000.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	1,126,600.00	0.00
210304	Байрны түрээс	14,531,600.00	14,531,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,085,000.00	24,866,489.00
210401	Бичиг хэрэг	3,400,000.00	3,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,520,000.00	14,519,100.00
210403	Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	3,405,000.00	3,187,389.00
210404	Ном, хэвлэл	360,000.00	360,000.00
210406	БҮТЭЗүйлс	3,400,000.00	3,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,800,000.00	11,800,000.00
210601	Багаж,техник хэрэгсэл	5,000,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	6,800,000.00	6,800,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,560,400.00	1,560,400.00
210702	Дотоод албан томилолт	1,560,400.00	1,560,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,123,900.00	3,042,252.00
210803	Даатгалын үйлчилгээ	868,400.00	868,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,500.00	215,428.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	1,800,000.00	1,800,000.00
210807	Газрын төлбөр	185,000.00	103,424.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,955,300.00	5,954,474.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,915,200.00	3,914,374.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,040,100.00	2,040,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,786,400.00	3,786,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,786,400.00	3,786,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,урамшуулал	3,786,400.00	3,786,400.00
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	0.00	5,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	5,000,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	5,000,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	395,713,600.00	388,488,818.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	395,713,600.00	388,488,818.77
131001	Улсын төсвөөс санхүүжих	395,713,600.00	388,488,818.77

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Шижирболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 014/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газрын үйл ажиллагааны стратеги зорилго нь "Монгол Улсын нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх цагаачлалын бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын оновчтой хэлбэр, чадварлаг ажиллах хүчин бүхий олон улсын жишигт нийцсэн ажил, үйлчилгээг гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэх төрийн захиргааны байгууллага болох" гэж тодорхойлжээ.

Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газар 2016-2021 онд хэрэгжүүлэх стратеги зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн ажил үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чанартай, шуурхай, хүртээмжтэй, нээлттэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах
- Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох
- Удирдлагын манлайллыг хангах хүний нөөцийн хэрэгцээг оновчтой тодорхойлох, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг шат дараатайгаар дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төсөвлөх санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах
- Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх
- Хяналт шинжилгээ, дотоод аудит хийж, үр дүнд үнэлгээ өгөх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилах сэргийлэх ажиллагааг тогтмол зохион байгуулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд хяналт шинжилгээ үнэлгээ дотоо аудитын хэлтсийн хяналтаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна. Харин хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 09/11 дугаар албан бичгээр тус байгууллагад зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 5,246.2 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 524,623,359 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,246.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,672.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гадаадын иргэн харьяатын газар өмнөд бүс дэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93,107.1 мянган төгрөгөөр буюу 31,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	46,557.3	57,739.0	11,181.7
Биет хөрөнгө	210,722.9	293,143.3	82,420.4
Биет бус хөрөнгө	35,666.3	35,171.3	(495.0)
Нийт хөрөнгө	292,946.4	386,053.6	93,107.2
Хуримтлагдсан үр дүн	212,091.3	305,198.5	93,107.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	292,946.4	386,053.6	93,107.2

Бараа материалын дансны үлдэгдэл 11,181.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бусад хангамжийн 11,029.2 мянган төгрөгийн материал шилжүүлж авснаас шалтгаалжээ. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 82,420.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд машин тоног төхөөрөмж 30,695.6 мянган төгрөг, тавилга эд хогшил 102,291.6 мянган төгрөгийн материал шилжүүлж авснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 495.0 мянган төгрөгөөр буурсан программ хангамжийн элэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 305,198.5 мянган төгрөг болж 93,107.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны 93,107.2 мянган төгрөгийн ашгаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 474,338.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийг Сангийн яамны шийдвэрээр 78,624.6 мянган төгрөгөөр бууруулж, 395,713.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 395,713.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 395,713.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 395,713.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 388,488.8 мянган төгрөгийг зарцуулж 7,224.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 388,488.8 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 2,954.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,743.2 мянга төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,226.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 215.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 81.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 нэр төрлийн 47 ширхэг үндсэн хөрөнгө байна. Эдгээр хөрөнгийг актлах, устгах, зарим ашиглах боломжтой үндсэн хөрөнгөнд үнэ тогтоох саналыг дээд шатны газартаа хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнээс 1 албан шаардлагыг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын цаг бүртгэлийн систем хангалттай үнэн зөв ажиллахгүй байна. Иймд дараагийн аудитаар уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж, сайжруулсан байдлын хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,027.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,027.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав. Аудитаар зөвлөмж, албан шаардлага, акт өгөөгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу /нэхэмжлэх нь эх хувиар бус/ баримтаар 3,027.7 мянган төгрөгийн 10 ажил гүйлгээг бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГИХГ-Өмнөд бүс дэх газар	1	3,027.7	1	3,027.7	-	-	-	-	-	-